

4. Энэ тогтоолын 1-д заасан хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг бүртгэсэнтэй холбогдуулан дараах арга хэмжээг цаашид хэрэгжүүлж ажиллахыг “МИК ОССК” ХХК /Б.Гантулга/-д үүрэг болгосугай:

1/ Баталгаат үнэт цаасаар баталгаажсан зээлийн багцад буй зээлдэгчдийг Хорооны 2018 оны 210 дугаар тогтоолоор баталсан “Ипотекийн даатгалын үйл ажиллагааны журам”-ын дагуу ипотекийн даатгалд бүрэн хамруулах;

2/ Хороонд судалгаа, шинжилгээнд шаардлагатай холбогдох мэдээ, мэдээллийг тухай бүр гаргаж ирүүлэх;

3/ Анх бүртгүүлсэн барьцаа хөрөнгийн үнэлгээний нийлбэр дүн, хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаасны урт хугацаатай өглөгийн дүн, үндсэн болон хүүгийн төлбөр төлөлтийн талаарх мэдээллийг сар бүр тогтмол Хороонд ирүүлж байх.

5. Энэхүү тогтоолын 2-т заасан гэрээний дагуу үнэт цаас худалдан авсан хөрөнгө оруулагчдын үнэт цаасны өмчлөх эрхийг баталгаажуулан бүртгэх, бүртгэлийн талаарх мэдээллийг улирал бүр гарган ирүүлж ажиллахыг “ҮЦТХТ” ХХК /Ж.Байгалмаа/-д үүрэг болгосугай.

6. Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан Монголбанк /Б.Лхагвасүрэн/, Сангийн яам /Ч.Хүрэлбаатар/-д дараах арга хэмжээ авч ажиллахыг тус тус зөвлөсүгэй:

1/ Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуульд заасны дагуу анхны үүрэг гүйцэтгүүлэгч болон үйлчилгээ үзүүлэгч банкинд Банкны тухай хууль болон холбогдох бусад хууль, журамд заасан бүрэн эрхийнхээ хүрээнд тогтмол хяналт тавьж ажиллах;

2/ Банканд олгосон ипотекийн санхүүжилтийн эх үүсвэрийн зориулалт, ашиглалт, эргэн төлөлтөд тавьж буй хяналт шалгалтын тайлан, мэдээг Хороонд ирүүлэх;


3/ Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны санхүүжилтийн эх үүсвэрийн зардлыг төсөвт дарамт учруулахгүйгээр шийдвэрлэж, зах зээлийн зарчмаар хөгжүүлэх чиглэлд анхаарал хандуулан ажиллах.

7. Энэ тогтоолын 1-д заасан баталгаат үнэт цаасыг баталгаажуулж буй зээлийн багц дахь мэдээлэл, үл хөдлөх хөрөнгийн үнэлгээ болон холбогдох бусад мэдээлэл нь үнэн зөв эсэхийг үнэт цаас гаргагч “МИК актив хорин дөрөв” ХХК /Т.Мөнхжаргал/, хөрөнгө итгэмжлэн удирдагч “МИК ОССК” ХХК /Б.Гантулга/ болон энэ тогтоолын 2 дугаар хавсралтад дурдсан нэр бүхий анхны үүрэг гүйцэтгүүлэгч 10 арилжааны банк хариуцахыг дурдсугай.

8. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Т.Жамбаажамц/-нд даалгасугай.

ДАРГА  Д.Б. ЯРСАЙХАН


Санхүүгийн зохицуулах хөрооны
2020 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн
345 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралт



“МИК актив хорин дөрөв” ХХК-ийн гаргаж буй орон сууцны
зээлээр баталгаажсан баталгаат үнэт цаас

Баталгаат үнэт цаасны төрөл	Нэрлэсэн үнэ /төгрөгөөр/	Тоо ширхэг	Жилийн хүү	Хугацаа	Нийт хэмжээ /төгрөгөөр/	Эзлэх хувь
Давуу эрхтэй баталгаат үнэт цаас I	100,000	235,309	1.0%	30 хүртэл жил	23,530,900,000	20.5%
Давуу эрхтэй баталгаат үнэт цаас II	100,000	654,242	4.5%	30 хүртэл жил	65,424,200,000	57.1%
Давуу эрхтэй баталгаат үнэт цаас III	100,000	141,183	13.0%	30 хүртэл жил	14,118,300,000	12.3%
Энгийн баталгаат үнэт цаас	100,000	114,534	10.5%	30 хүртэл жил	11,453,400,000	10.0%
Нийт	100,000	1,145,268	-	-	114,526,800,000	100%

Санхүүгийн зохицуулах хорооны
2020 оны 06 дугаар сарын 09 -ны өдрийн
345 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралт



“МИК актив хорин дөрөв” ХХК-д орон сууцны зээл
багцлан худалдаж буй анхны үүрэг гүйцэтгүүлэгчид

№	Анхны үүрэг гүйцэтгүүлэгч	Зээлийн багц хөрөнгө /төгрөг/	Зээлийн дансдын тоо	Нийт зээлийн багцад эзлэх хувь хэмжээ
1	“Богд банк” ХХК	3,934,897,540.65	57	3.44
2	“Голомт банк” ХХК	18,918,757,404.77	324	16.52
3	“Капитрон банк” ХХК	7,827,866,780.81	150	6.83
4	“Төрийн банк” ХХК	13,590,304,179.00	174	11.87
5	“Улаанбаатар хотын банк” ХХК	1,555,084,221.87	16	1.36
6	“Хаан банк” ХХК	25,625,449,049.47	476	22.37
7	“Хас банк” ХХК	14,867,864,332.07	300	12.98
8	“Худалдаа хөгжлийн банк” ХХК	26,404,384,935.90	379	23.06
9	“Чингис хаан банк” ХХК	1,650,612,769.62	20	1.44
10	“Үндэсний хөрөнгө оруулалтын банк” ХХК	152,501,516.45	1	0.13
	Нийт	114,527,722,730.61	1,897	100.00